



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 02

Номгон

Ухаалаг Баянхонгор аймгийн
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн II хуралдааны 2/3 дугаар тогтоолоор баталсан “Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 134 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Ухаалаг Баянхонгор аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, шаардлагатай төсөв, зохион байгуулах ажлыг аймгийн жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусгаж батлуулан, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 31-ний
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт



УХААЛАГ БАЯНХОНГОР
АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн танилцуулга

Дэлхийн олон оронд хэрэглэж буй “Ухаалаг хот” гэдэг үг нь анх мэдээллийн технологи дээр суурилсан харилцаа холбоо, үйлчилгээний өндөр хөгжилтэй гудамжнууд буюу IT District гэдэг үгнээс үүссэн нэр томьёо юм. Ухаалаг хот нь маш олон салбарыг хамарсан цогц утгыг илэрхийлэх томоохон төслүүдийн нэгдлийг илэрхийлнэ. Хүн амын төвлөрөл бүхий цаашид хүн ам өсөх ирээдүйтэй хотуудыг ухаалаг хот хэлбэрээр хөгжүүлэхэд хамгийн тохиромжтой гэж үзжээ.

Сүүлийн жилүүдэд Монгол орон хөгжлийн шинэ шатанд гарч аймгийн төвүүдийг хот болгон хөгжүүлэх, хотын доторх хорооллуудыг дахин төлөвлөх, шинээр барих зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг газар газарт төлөвлөн ажиллаж байна. Энэ чиг хандлага нь аль нам, улс төрийн хүчин төр барьж байгаагаас үл хамааран цаашид зогсолтгүй үргэлжилж дэлхийн жишигт нийцсэн тайван амгалан, хүнээ дээдэлсэн орчин үеийн хотуудыг бий болгоно гэдэгт олон хүн итгэлтэй байдаг. Айл өрх, хот суурин, хөгжихийн тулд тогтвортой байдлаа сайн тооцох нь хамгийн чухал бөгөөд “Ухаалаг Баянхонгор” хөтөлбөрт хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь түүнд чиглэгдэх ба гол зорилго нь хүний сайн сайхан, оршин суугчдын амар тайван амьдрах орчинг бүрдүүлэх явдал юм. Энэ орчинг бүрдүүлэхийн тулд хамгийн ухаалаг шийдлүүдийг ашиглаж эдгээр нь хоорондоо нягт харилцан холбоотой байх ёстой бөгөөд үүнийг core systems буюу “нэг цөмт тогтолцоо” хэмээн нэрлэдэг.

“Ухаалаг Баянхонгор” хөтөлбөр нь мэдээллийн технологийн салбартай шууд уялдах бөгөөд “Аж үйлдвэрийн 4-р хувьсгал” буюу “Дижитал Шилжилт” гэдэг ойлголтын тухай сүүлийн үед маш хүчтэй яригдаж түүнийг дагасан төрийн бодлогын хөтөлбөр, төслүүд хэрэгжих байна. Хурдацтай өсөн нэмэгдэж буй технологийн нөлөөгөөр өгөгдөл цуглуулах, боловсруулах, дамжуулах, хадгалах, хурд, хэмжээ, багтаамж асар ихээр нэмэгдсээр байна. Энэ нь хүмүүсийн амьдралд энгийн хэрэглээний түвшинд нэвтэрснээр хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээний

талаарх мэдээлэл, үйлчилгээ цаг алдалгүй хүрч, тэдэнд өргөн сонголт, төлбөрийн уян хатан нөхцлийг бий болгох нөгөө талаар Төрийн үйл ажиллагаа, санах ойг боловсронгуй болгох гэх мэт олон давуу тал бий болгох шийдлүүдийг нэвтрүүлэх юм.

1.1.Ухаалаг хотын тогтолцооны цөмд нягт холбогдох ёстой гол хүчин зүйлс

1.1.1.Дэд бүтцийн тогтолцоо

1.1.2.Засаг захиргааны тогтолцоо

1.1.3.Боловсролын тогтолцоо

1.1.4.Эрүүл мэндийн тогтолцоо

1.2.Ухаалаг хотыг тодорхойлох шинж чанар: Ухаалаг хотыг тодорхойлох хэд хэдэн хүчин зүйлүүд байна. Дэлхийн ухаалаг хотуудын жагсаалтыг гаргахдаа голлон авч үзсэн үзүүлэлтүүдийг орууллаа. Эндээс бид чухам юун дээрээ анхаарах ёстойг мэдэх боломжтой.

1.1.1 УХААЛАГ ЗАСАГЛАЛ-иргэдийн оролцоо

- Шийдвэр гарах түвшин дэх иргэдийн оролцоо
- Нийгэм, олон нийтийн үйлчилгээ
- Засаглалын тунгалаг байдал
- Улс төрийн стратеги, хэтийн төлөв
- Засаглал, иргэдийн оролцооны мэдээллийн систем

1.1.2 УХААЛАГ ЭДИЙН ЗАСАГ-өрсөлдөх чадварын үзүүлэлтүүд

- Бизнес эрхлэлтийн байдал, бизнес эрхлэх боломж
- Эдийн засгийн нүүр царай, брэнд, худалдааны тэмдэгтүүд
- Бүтээмж
- Шинэчлэн сайжруулах чадвар, хүсэл эрмэлзэл
- Хөдөлмөрийн зах зээл дээрх уян хатан чанар
- Олон улсын стандартад тохирсон байдал
- Ухаалаг эдийн засгийн мэдээллийн систем

1.1.3 УХААЛАГ ИРГЭД-нийгмийн харилцаа, хүн капитал

- Боловсрол, мэргэшлийн төвшин
- Удаан хугацаанд суралцах хүсэл эрмэлзэл, боломж
- Олон нийтийн, цөөнхийн хамаарал
- Оршин суугчдад үзүүлэх засаг захиргааны уян хатан байдал
- Сэтгэлгээний бүтээлч чанар
- Үзэл бодлын чөлөөт байдал

- Иргэдийн нийгмийн идэвхи

1.1.4 УХААЛАГ ЗАМ ТЭЭВЭР, ХАРИЛЦАА-зам тээвэр, мэдээлэл харилцааны технологи

- Орон нутаг дахь тээвэр, харилцааны саадгүй байдал
- Улс орны хэмжээнд болон олон улсад харилцах, зорчих саадгүй байдал
- Мэдээлэл, харилцааны дэд бүтцийн боломжит байдал
- Шинэтгэн сайжруулж болох тогтвортой хөгжил бүхий аюулгүй зам тээврийн харилцаа
- зам, тээврийн мэдээллийн систем

1.1.5 УХААЛАГ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН-байгалийн эх үүсвэрүүд

- Байгалийн хүчин зүйлээр анхаарал татах боломж
- Агаарын бохирдол
- Хүрээлэн буй орчны хамгаалалт
- Байгалийн нөөцийг тогтвортой, хэмнэлттэй ашиглах менежмент
- Хүрээлэн буй орчны мэдээллийн систем

1.1.6 УХААЛАГ АМЬДРАЛ-амьдралын чанарын үзүүлэлтүүд

- Соёл, урлаг, спортын байгууламжуудаар хангагдсан байдал
- Эрүүл мэндийн үзүүлэлтүүд
- Хувь хүний эрх чөлөөг хангасан байдал
- Орон сууцжуулсан түвшин
- Боловсролын үйлчилгээгээр хангагдсан байдал
- Жуулчдыг татах боломжуудаар хангагдсан байдал
- Нийгмийн хамтын үр бүтээлтэй үйл ажиллагаа

Эдгээр хүчин зүйлүүдийг урт хугацаанд төлөвлөн суурийг нь маш сайн тавьж өгөх нь УХААЛАГ хоттой болох хамгийн эхний алхам аж. Хөгжиж буй орнууд хотын хөгжлийг илүү ухаалаг болгох тал дээр маш их анхаарлаа хандуулах болсон бөгөөд мэргэжлийн өндөр чадвар бүхий судалгааны багууд эрчимтэйгээр ажиллаж байна. Энэ нь хотын хөгжил зэрэг олон зүйлд голлох үүрэг гүйцэтгэдэг чухал хэсэг байдгаас үүдэлтэй.

Монгол Улсын хувьд бол харьцангуй залуу аймаг, хотуудтай бөгөөд ялангуяа баруун бүсийн тулгуур аймаг болохыг зорьдог манай аймгийн хувьд илүү ухаалаг хөгжих бүрэн боломж байгаа юм. Үүнд өндөр түвшний судалгаа, дагаж мөрдөх зарчим, стандарт, нийгмийн идэвхийг сайжруулах соён гэгээрүүлэх (PR)

үйл ажиллагаанууд, байгаль орчны асуудлууд, хотын тохижилт, моджуулалт, зүлэгжүүлэлт ландшафтын ажлууд, жуулчдыг татах, хүлээн авах үйлчилгээг сайжруулах, мэдээллийн технологийн оновчтой шийдлүүд, дэд бүтцийн ажлууд эхний ээлжид хийгдэх хэрэгтэй юм

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

Энэхүү хөтөлбөрт заасан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.Ухаалаг шийдэл. (Smart solution) Хүн, үйлчилгээ, тоног төхөөрөмж, байгууламжуудын үйл ажиллагааг хөнгөвчлөн, зардал хэмнэж, мэдээлэл, менежментийн шинэ боломж нээдэг технологи шийдлүүдийг;

2.2.Ухаалаг хот. (Smart city) Хотын бүх салбар нэгжийн үйл ажиллагаанд ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлсэн хотыг;

2.3.Төрийн үйлчилгээний төв. (Citizen service center) иргэн ямар баг, хороонд амьдардгаас үл хамааран, төрийн бүх төрлийн үйлчилгээг авч болох төв юм. Төвүүд нь төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санд (Үндэсний Дата төв)-д шууд холбогдсон байна (Төрийн үйлчилгээний нэгдсэн төв).

2.4.Цахим засаглал. (e-Government) төрийн үйлчилгээг мэдээллийн технологийн тусламжтайгаар хөнгөвчилж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай нээлттэй хүргэх боломжийг бүрдүүлэх бүтэц, үйлчилгээ, системийг (Цахим мэдээллийн нэгдсэн сан);

2.5.Цахим үйлчилгээ. (e-Service) Компьютер болон мэдээллийн технологийн бусад хэрэгслүүдээр авч болох төрийн үйлчилгээг; Мэдээлэл авах, хяналт тавих, бусдыг үнэлэх, үйлчлүүлэх зэрэг мэдээллийн сүлжээгээр дамжуулан алсаас авч болох бүх төрлийн үйлчилгээг хамарна(Цахим мэдээлийн нэгдсэн сан).

2.6.Иргэний цахим нэг цонх. (Citizens web single windows) Аймгийн иргэн бүр өөрт хамааралтай бүх мэдээлэл, үйлчилгээг нэг веб цонхноос харж, харилцах боломж олгох цахим үйлчилгээ(www.bayankhongor.gov.mn).

2.7.Төрийн ажилтны цахим ажлын байр. (e-Office) төрийн үйлчилгээний ажилтан өдөр тутмын ажил үйлчилгээгээ цахим хэлбэрээр явуулахад туслах тусгайлсан мэдээллийн системийг (ABLE байгууллагын дотоод удирдлагын програм);

2.8.Шилэн данс, шилэн тендер. (Transagency) ажиллахад хялбар, бүгдэд хүртээмжтэй, үйлдэл нь ойлгомжтой нийтийн хяналтын нээлттэй орчинг бий болгох системийг; Интернетэд холбогдсон иргэн бүр төрийн бүхий л төрлийн үйл

ажиллагааг цаг минут тутам хянах боломжтой болно(shilendans.gov.mn, tender.gov.mn).

2.9.Зөөлөн дэд бүтэц. (Soft Infrasrtructure) Зөөлөн дэд бүтцэд гарт баригдаж, нүдэнд үзэгддэггүй харилцаа, зохицуулалтуудыг хамруулан авч үздэг. Жишээлбэл төр иргэдийн харилцаа, эдийн засгийн харилцаа, боловсрол, соёлын уламжлал, мэдээллийн системүүд г.м. өөрөөр хэлбэл хатуу дэд бүтцийг өгөөжтэй, зөв ашиглахад гол үүрэг гүйцэтгэдэг хэсэг юм.

2.10.Үүлэн тооцоолуур. (Cloud computing) Хаанаас ч, хэзээ ч, боломжит техник, хэрэгслээрээ мэдээллийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлдэг интернетэд тулгуурласан технологи (Үндэсний дата төвд байршуулах “Баянхонгор дата сервэр”).

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Шинэ зууны технологийн дэвшилд тулгуурлан хэмнэлтийг бий болгосон Баянхонгор аймгийн хөгжлийн чиг хандлага, иргэдийн хүсэл шаардлага, бизнесийн орчны өөрчлөлт, аялалын таатай орчин зэргийг оновчтой шийдвэрлэж, ойлгомжтой дүрэм журамтай, соёлтой шуурхай үйлчилгээтэй, технологижсон, ажиллаж амьдрахад таатай, аюулгүй ухаалаг, аймгийг бий болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

Дөрөв. Хөтөлбөр боловсруулсан үндэслэл, зорилт үндэслэл:

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмж

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

Зорилго

Зорилт 1: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, үйл ажиллагааны зардлыг бууруулах

Зорилт 2: Хувийн хэвшлийн байгууллагууд, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх,

Зорилт 3: Баянхонгор аймгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх,

Зорилт 4: Иргэд технологийн дэвшил, мэдээллийн эрин үед ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх

Хөтөлбөрийг боловсруулах хэрэгцээ шаардлагууд

4.1.Аймгийн хэмжээний нийт төрийн байгууллагаас иргэд, аж ахуйн нэгжид үзүүлж байгаа төрийн үйлчилгээний тодорхой хэсгийг цахим хэлбэрт шилжүүлж цахим нэг цонхоор үйлчилгээ үзүүлэх боломжтой юм. Ингэж оновчтой аргачлалаар, зөв зохион байгуулалттай, технологийн дэвшил болон үйл ажиллагааны өөрчлөлтийг зүй зохистой хослуулснаар төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, чирэгдэлгүй тэгш хүргэх боломж бүрдэх юм.

4.2.Хүн амын өсөлтөөс хамаарч үүсэх хүндрэлүүдийг шийдвэрлэж чадах, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах шинэ шийдлүүд тулгамдаж байна. Хүн амын өсөлт болон бизнесийн өрсөлдөөний хэрэгцээ шаардлагад дасан зохицож, хотын тогтвортой хөгжлийг урт хугацаанд хангах үндэс суурь болон сайн засаглалыг бүрдүүлэхэд дэд хөтөлбөр чиглэгдэнэ.

4.3.Дэлхийн ухаалаг хотуудын нийтлэг зорилт бол хотын оршин суугчдын хүсэл сонирхлыг мэдэрч, хэрэгцээнд нийцсэн орчинг бүрдүүлэх явдал юм. Иргэд аюулгүй, эрүүл орчинд амар тайван амьдрах ёстой. Энэхүү хөтөлбөр нь эдийн засгийн өсөлтийг ханган, зардлыг бууруулж, шуурхай соёлтой үйлчилгээг нэвтрүүлэхэд чиглэсэн хүн, үйлчилгээ, технологийн цоо шинэ цогц шийдлийг нэвтрүүлж иргэддээ үйлчлэх аймгийг байгуулах эхлэл тавигдана.

4.4.Аймагт үйл ажиллагаагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн салбар нэгжүүдийг хамрах бөгөөд шударга өрсөлдөөн, авлигагүй орчинг бүрдүүлэх, олон төрлийн үйлчилгээ бүхий шинэ технологийг хотын амьдралд нэвтрүүлэх юм.

4.5.Байгальд ээлтэй технологи, ногоон байгууламж, дахин боловсруулалтын шинэ шийдэл бүхий ногоон хотыг байгуулж, орчны бохирдлыг хянан, эрүүл орчин бүрдүүлнэ.

4.6.Хот, суурин бол олон төрлийн дэд бүтэц, үйл ажиллагаа, амьжиргааны хэв маяг хосолсон нийлмэл том систем юм. Энэ том системийг онолын дагуу нэгтгэж, удирдан зохицуулах боломжийг ухаалаг хотын шийдлүүд олгоно. Салангид удирдлагаас нэгдсэн хяналт, удирдлагад оруулах нь Ухаалаг аймгийн үйл ажиллагааны удирдлагын мэдээллийн нэгдсэн системийн үндсэн үүрэг юм.

Тав. Хөтөлбөрийн хамрах хүрээ

“Ухаалаг Баянхонгор” хөтөлбөр нь дараах хүрээний үйл ажиллагааг сайжруулах зорилтыг дэвшүүлж байна.

5.1.Ухаалаг засаглал (Smart Governance) Нээлттэй, ил тод иргэдийн оролцоог хангасан цахим засаглалыг нэвтрүүлэх.

5.2.Ухаалаг эдийн засаг (Smart Economy) төр бизнесийн харилцааг сайжруулах, аймгийн тогтвортой хөгжлийг хангахуйц, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихэд туслах.

5.3.Ухаалаг иргэд (Smart Citizens) үндэсний оюуны чадавхад тулгуурласан, шинжлэх ухаан, технологи, инновацийн тогтолцоог хөгжүүлэх орчин бүрдүүлэх.

5.4.Ухаалаг үйлчилгээ: (Smart Services) Аймгийн мэдээллийн орчин, дэд бүтцийг уян хатан, хүртээмжтэй, найдвартай болгон хөгжүүлж, төрийн үйлчилгээг хялбаршуулах #ХУР, #ДАН гэх мэт цогц шийдлийг нэвтрүүлэн хэрэгжүүлэх

5.5.Ухаалаг орчин (Smart Environment) Ая тухтай, эрүүл, орчинд таатай ажиллаж, амьдрах боломжийг бүрдүүлэх.

5.6.Ухаалаг амьдрал (Smart Living) Иргэд шаардлагатай мэдээлэл үйлчилгээг гэрээсээ шууд авах нөхцөл бүрдсэн орон сууц, барилга байгууламж, амьдрах орчинд үйлчилгээний дэд бүтцийг бий болгох.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, зарчмууд

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах үндсэн зарчмуудыг баримтална.

6.1.Аймгийн тогтвортой хөгжлийг хангахуйц, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихэд бизнесийн зөв харилцааг бий болгоно.

6.2.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх бүх арга хэмжээнд үйл ажиллагааны өөрчлөлтийн инноваци, технологийн тэргүүн шийдлүүдийг хослуулан хэрэглэнэ.

6.3.Нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, иргэдийн бүтээлч хамтын ажиллагааг хөтөлбөрийн хүрээнд хийгдэх бүх ажилд оновчтой санал санаачилгыг тусган, өндөр технологи нутагшуулна.

6.4.Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлуудыг чадварлаг төслийн багаар гүйцэтгүүлнэ. Үүний үр дүнд мэргэжлийн сайн багийг хөтөлбөрийн гүйцэтгэлд татан оролцуулж, үйл ажиллагаа бүрийн гүйцэтгэлийн хурд ба чанарыг дээшлүүлж, төслийн гүйцэтгэлд олон улсын стандарт, хариуцлагын өндөр тогтолцоог мөрдүүлнэ.

6.5.Орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг төлөвлөлт, зохицуулалт, хяналт давамгайлсан хэлбэрт шилжүүлэн өөрчлөхөд чиглэнэ.

6.6.Хөтөлбөрийн бүх ажлууд нь иргэдийн эрх ашгийг дээдэлсэн, үйл ажиллагааны харилцаа холбоог сайтар хангасан, мэдээллийн нэгдсэн орчинг

бүрдүүлсэн, үр дүнг чухалчилсан, ажлын бүтээмжийг дээшлүүлсэн байхаар хийгдэнэ.

Долоо. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагаанууд

7.1.УХААЛАГ ЗАСАГЛАЛ: Зөв бүтэц, бүх нийтийн оролцоотой ухаалаг шийдвэрүүд, ил тод ойлгомжтой үйл ажиллагаа, төрийн үйл ажиллагааны соёлтой орчинг бий болгох ухаалаг засаглалыг аймгийн хэмжээнд бий болгоно. Энэхүү үндсэн чиглэлийн хүрээнд хийгдэх ажлууд:

7.1.1. Аймгийн хөгжлийн бодлого, үйл ажиллагаа:

7.1.1.1.“Ухаалаг Баянхонгор” хөтөлбөр нь “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийн дагуу батлагдан хэрэгжинэ.

7.1.1.2 “Ухаалаг Баянхонгор” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт тавих нэгдсэн удирдлагын бүтцийг бий болгоно.

7.1.1.3.Мэдээллийн дүн шинжилгээнд тулгуурласан урьдчилан тааварлах систем бий болгоно.(Big data).

7.1.2. Хууль эрх зүйн хүрээний оновчлол, шинэчлэл.

7.1.2.1.Аймгийн хэмжээнд үйлчилж байгаа нийт хууль эрх зүйн акт журам, шийдвэрийн нэгдсэн сантай болно.

7.1.2.2.Төрийн захиргааны байгууллагын удирдлагын шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянах тогтолцоог цахим хэлбэрт шилжүүлнэ.

7.1.3. Аймаг, орон нутгийн харьяа байгууллагуудын цахим үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх.

7.1.3.1.“Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, зарим үйлчилгээг цахим хэлбэрт оруулна.

7.1.3.2.Хүн ам, өрхийн нарийвчилсан цахим мэдээллийн нэгдсэн сан бий болгоно.

7.1.4. Аймгийн сайн засаглал, үйл ажиллагааны бүтээмжийн удирдлага (менежмент)

7.1.4.1.“Төрийн байгууллагын цахим хэрэглээний журам”-ыг боловсруулж хэрэгжүүлнэ.

7.1.4.2.Төрийн байгууллагын мэдээллийн технологи болон хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албан хаагчдыг чадавхижуулах сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулна.

7.1.4.3.Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, чадавхийг сайжруулах сургалтыг тогтмолжуулна.

7.1.4.4.Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг үнэлж орон тооны ажилтантай болох эсхүл мэргэжлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх замаар хэрэгцээ шаардлагыг хангана.

7.1.5. Ил тод байдлыг хангах, нээлттэй шударга орчинг бүрдүүлэх.

7.1.5.1.Байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжиж байгаа Шилэн данс системийн мэдээллийг иргэдэд хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар тайлагнадаг болгоно.

7.1.5.2.Бүх төрлийн тусгай зөвшөөрөл, лиценз олголтын явцыг нийтэд ил тод байлгах системийг нэвтрүүлнэ.

7.2. УХААЛАГ ЭДИЙН ЗАСАГ

7.2.1. Инновацийг дэмжсэн аймаг болох

7.2.1.1.Технологийн инновацийн шинэ санал санаачлагуудыг дэмжин хэрэгжүүлнэ.

7.2.1.2.Хүүхэд залуучуудын програм болон техник сэтгэлгээг хөгжүүлэх боломж бүрдүүлэх лаборатори байгуулна.

7.2.1.3.Аймгийн нэгдсэн мэдээллийн санд анализ, дүн шинжилгээ хийх мэдээлэл зүйн нэгж байгуулна.

7.2.2. Бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлэх.

7.2.2.1.Төсвийн хөрөнгөөр ажил үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийг дотооддоо үнэлэх үнэлгээний систем бий болгоно.

7.2.2.2.Бүс нутгийн аялал жуулчлал, бизнесийг дэмжих технологийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.

7.2.2.3.Хувийн аж ахуйн нэгжүүдэд мэдээллийн сан ашиглах тусгайлсан боломж олгоно.

7.2.3. Баянхонгор аймгийн брэнд бий болгох.

7.2.3.1.Баянхонгор аймаг, сумдын ерөнхий өнгө төрх, гудамж талбай, барилга байгууламж, төрийн үйлчилгээний стандарт, бусад төрлийн дизайныг тодорхойлох “Brand Book” бүтээнэ.

7.2.3.2 Аймгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах “Баянхонгор аймагт үйлдвэрлэв” цахим худалдаа, мэдээллийн платформыг хөгжүүлнэ.

7.2.4. Хөдөлмөрийн зах зээлийг идэвхжүүлэх.

7.2.4.1.Хөдөлмөр зуучлалын үйл ажиллагааг цахимжуулж, онлайн индекс хөтөлнө

7.3. УХААЛАГ ИРГЭД

7.3.1. Боловсролтой, мэдлэгтэй иргэн

7.3.1.1.Цахимаар боловсрол олгох орчинг бүрдүүлнэ.

7.3.1.2.Сургалт нөлөөллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн ИНБ-уудыг дэмжиж хамтран ажиллана.

7.3.1.3.Боловсролын салбарын хүний нөөцийг үнэлэх цахим систем бий болгоно.

7.3.1.4.ЕБС-ийн цахим картын бүртгэл, нэвтрэлтийн систем нэвтрүүлнэ.

7.3.1.5.ЕБС-ийн цахим номын сан байгуулна.

7.3.1.6.Иргэдэд мэдлэг, мэдээлэл хүргэх богино долгионы радио(FM) суваг ашиглана.

7.3.2. Хотын соёл-Иргэний бахархал

7.3.2.1.Дундын өмчлөлийн эд хөрөнгө, аж ахуй ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.

7.3.2.2.Нийтээр даган мөрдүүлэх дүрмийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна

7.3.3. Эрүүл, идэвхтэй хүн.

7.3.3.1.Сайн дурын үйл ажиллагааг дэмжин ажиллана. Сайн дурын үйл ажиллагаа эрхлэх иргэд, ААН-үүдийг хооронд нь холбох, үнэлэх системийг бий болгох.

7.4. УХААЛАГ ҮЙЛЧИЛГЭЭ.

7.4.1. Төр-Иргэний үйлчилгээ

7.4.1.1.Төр иргэний хоорондын харилцааг холбох цахим орчин бүрдүүлнэ.

7.4.1.2.Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй #ХУР, #ДАН системийг аймагтаа салбарт бүрт нэвтрүүлж эхэлнэ.

7.4.1.3.Шууд дамжуулалтын цахим систем (Live streaming) хөгжүүлнэ.

7.4.2. Төрийн үйлчилгээний хурд, хүртээмж.

7.4.2.1.Төрийн байгууллагуудыг үйл ажиллагаа, хяналт, удирдлагын нэгдсэн систем (able) ашиглалтыг сайжруулж цаасгүй технологи руу бүрэн шилжинэ.

7.4.2.2.Бүх сумдад цахим хурлын системүүдийг нэвтрүүлнэ.

7.4.2.3.Төрийн байгууллагуудад цахим хяналт, мэдээллийн системийг хөгжүүлж аймгийн удирдлагуудыг өдөр тутмын нэн шаардлагатай мэдээллээр хангана.

7.4.2.4.Эрүүл мэндийн салбаруудын анхан шатны маягтуудыг цахимжуулах.

7.4.2.5.Эрүүл мэндийн цахим автомат зөвлөгч систем ажиллуулна.

7.4.2.6. Оношилгоо, шинжилгээний мэдээллийг цахимаар шууд хянах сан үүсгэх.

7.5. УХААЛАГ ОРЧИН

7.5.1. Эрүүл аюулгүй амьдрах орчин бүрдүүлнэ.

7.5.1.1. Хог хаягдал, орчны бохирдлын хяналт, арчилгаа, дахин боловсруулалтын үр өгөөжтэй шийдлүүдийг нэвтрүүлнэ.

7.5.1.2. Аймгийн суурьшлын бүсүүдийг хамарсан гэрэлтүүлэг, камержуулалттай орчинг бий болгоно.

7.5.2. Мэдээллийн дэд бүтцийг байгуулах

7.5.2.1. Үндэсний дата төвийг түшиглэн аймгийн хэмжээний “Дата төв”-ийг байгуулна.

7.5.2.2. Аймгийн суурьшлын бүсүүдийг хамарсан утасгүй сүлжээний дэд бүтэц байгуулна.

7.5.2.3. Төрийн байгууллагуудын цахим аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг сайжруулна.

7.5.2.4. Эрчим хүчний ухаалаг сүлжээ (Smart Grid) нэвтрүүлнэ.

7.5.2.5. Баянхонгор аймгийн усан хангамжийн шугам сүлжээнд ухаалаг автомажуулалтын системийг нэвтрүүлнэ.

7.5.3. Ухаалаг зам тээвэр, харилцаа

7.5.3.1. Төрийн авто тээврийн хяналт, удирдлагын систем бий болгох

7.5.3.2. Нийтийн тээврийн ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлнэ.

7.6. УХААЛАГ АМЬДРАЛ

7.6.1. Аюулгүй, амар тайван амьдрал

7.6.1.1. Барилга, зам тээврийн ослыг бууруулах тэмдэг тэмдэглэгээний хүртээмжийг сайжруулна.

7.6.1.2. Ахуйн болон байгууллагын галын дохиолол, хяналтын камер, хулгайн дохиолол гэх мэт автомат удирдлагын системүүдийг шуурхай удирдлагын төвүүдтэй холбох

7.6.1.3. Нийтийг хамарсан гэнэтийн гамшгийн (менежментийн) удирдлагын нэгдсэн систем байгуулна.

7.6.2. Ухаалаг эрүүл мэнд.

7.6.2.1. Амралт чөлөөт цагийг зөв өнгөрөөх цэгүүдийг олшруулна.

7.6.2.2. Ухаалаг мэдрэгч, хэмжигч, системүүдийг (Smart Meter, Smart Sensor) байршуулж нийтэд мэдээлэх боломжуудыг бүрдүүлнэ..

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шатууд, шаардагдах төсөв

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдэх инновацийн шийдэл, зохион байгуулалтын ажлуудыг дараах хугацаанд хэрэгжүүлж дуусна. Хөтөлбөрийг 2018-2024 оны хугацаанд дараах гурван үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Үүнд:

I үе шат-“Цахимжсан Баянхонгор” (2018-2020 онд)

II үе шат-“Технологижсон Баянхонгор” (2020-2022 онд)

III үе шат-“Ухаалаг Баянхонгор” (2022-2024 онд)

“Цахимжсан Баянхонгор” үе шатанд хийгдэх ажлууд нь “Технологижсон Баянхонгор” үе шатны хийгдэх ажлуудын суурь нөхцөлийг бүрдүүлнэ. “Технологижсон Баянхонгор” үе шат нь бүх дэд бүтцийг ухаалаг технологид шилжүүлж “Ухаалаг Баянхонгор” үе шатыг байгуулах нөхцлийг бүрдүүлнэ.

8.2. “Цахимжсан Баянхонгор” үе шатанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. (2018-2020 онд)

8.2.1. “Ухаалаг Баянхонгор” хөтөлбөрийг батлан үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн тооцоог боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.

8.2.2. Хөтөлбөрийн хүрээнд цахим шилжилт хийгдэх програм хангамжийн ажлуудыг салбар бүрээр багцлан төсөл болгон хэрэгжүүлнэ.

8.2.3. Баянхонгор сумын төвийг хамарсан (wireless) утасгүй сүлжээ, ухаалаг мэдрэгч, хэмжигч, орчны гэрэлтүүлэг, хяналтын камер болон нийтийг хамарсан гамшгийн удирдлагын нэгдсэн системүүдийн дэд бүтэц бий болгоно.

8.2.4. Үндэсний Дата төвийг түшиглэн Баянхонгор аймгийн “Дата төв”-ийн суурийг бий болгож мэдээллийн дүн шинжилгээнд тулгуурласан урьдчилан тааварлах системийн суурь мэдээллийн санг төвлөрүүлнэ.

8.2.5. Утасгүй сүлжээнд холбогдон интернэт ашиглах, аймгийн цахим мэдээллийн нэгдсэн системд үнэ төлбөргүй нэвтрэн мэдээлэл солилцох орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

8.2.6. “Төрийн байгууллагын цахим хэрэглээний журам”-ыг боловсруулж, мэдээллийн технологийн мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, шаардлагад дүн шинжилгээ хийн, мэргэжилтэй боловсон хүчнийг давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулна.

8.2.7. Нийтээр даган мөрдүүлэх дүрмийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх нөлөөллийн арга хэмжээг хөтөлбөрийн хэрэгжилтийн турш зохион байгуулна.

8.2.8. Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн “Цахимжсан Баянхонгор” үе шатны ажлуудыг дүгнэж, үнэлэх.

8.3. “Технологижсон Баянхонгор” үе шатанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. (2020-2022 онд)

8.3.1. “Цахимжсан Баянхонгор” үе шатны хүрээнд хийгдсэн цахим шилжилтийн ажлуудад нэмэлт хөгжүүлэлт хийгдэнэ.

8.3.2. Баянхонгор аймгийн “Дата төв”-ийн өргөтгөлийн ажлууд хийгдэж мэдээллийн дүн шинжилгээнд тулгуурласан урьдчилан тааварлах системийн ашиглалт эхэлнэ.

8.3.3. Орчны гэрэлтүүлэг, хяналтын камерын хамрах хүрээг нэмэгдүүлж тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудыг нэгдсэн хяналт, мэдээллийн системд холбоно.

8.3.4. Технологийн инновацийн шинэ санал санаачлагуудыг судалж оновчтой шийдэл бүхий төслийг хөтөлбөрийн хэрэгжилтийн турш дэмжинэ.

8.3.5. Дэд бүтцийн салбаруудад ухаалаг шийдэл бүхий технологи нэвтрүүлэн бодит хэмнэлтийг бий болгож эхэлсэн байна.

8.3.6. Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн “Технологижсон Баянхонгор” үе шатны ажлуудыг дүгнэж, үнэлэх.

8.4. “Ухаалаг Баянхонгор” үе шатанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. (2022-2024 онд)

8.4.1. Аймгийн ногоон эдийн засгийн үндсийг тавих (ЭКО) технологиудыг дэд бүтцийн бүх салбарт нэвтрүүлнэ. Хог хаягдал, бохир усыг дахин ашиглана.

8.4.2. Дэд бүтцийн салбаруудад ухаалаг шийдэл бүхий технологиуд бүрэн нэвтэрнэ.

8.4.3. Салбар бүрд нэвтрүүлсэн цахим шилжилт болон ухаалаг төхөөрөмжүүд хэрэглээнд бүрэн нэвтэрсэн байна.

8.4.3. Аймгийн нэгдсэн мэдээллийн санд анализ, дүн шинжилгээ хийх мэдээлэл зүйн нэгж байгуулан оновчтой үйл ажиллагааг хөгжлийн бодлого төлөвлөлтөд ашиглаж эхэлсэн байна.

8.5. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

8.5.1. Улсын төсвийн хөрөнгө.

8.5.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө.

8.5.3. Олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилт

8.5.4. Олон улсын банк санхүүгийн байгууллагын зээл тусламжийн хөрөнгө;

8.5.5. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;

8.5.6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг нарийвчлан тодорхойлж, жил бүрийн төсөвт тусгана.

8.5.7. Эхний үе шатуудад шаардагдах хөрөнгийн зарим хэсгийг аймгийн 2018, 2019 оны төсөвт тусган гүйцэтгэнэ.

8.5.8. Бусад эх үүсвэр.

Ес. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

9.1 “Ухаалаг Баянхонгор” хөтөлбөр хэрэгжсэнээр дараах байдлаар өөрчлөгдөнө. Үүнд:

9.1.1. Иргэдэд шуурхай, чирэгдэлгүй, тэгш үйлчилдэг аймаг болно.

9.1.2. Аймгийг ухаалгаар удирдах нэгдсэн мэдээллийн сантай болно. (Big data)

9.1.3. Авлигагүй, бизнест ээлтэй аймаг болно.

9.1.4. Аймгийн хэмжээнд сайн засаглалыг бүрдүүлнэ.

9.1.5. Салангид бус нэгдсэн системтэй Баянхонгорыг байгуулна.

9.1.6. Технологийн дэвшлийг үр дүнтэй нэвтрүүлж бодит хэмнэлт бий болгосон аймаг болно.

9.1.7. Эрүүл аюулгүй, иргэдэд ээлтэй орчин бүрдсэн байна.

9.1.8. Аялал жуулчлалыг дэмжсэн, жуулчдад нээлттэй орчин бүрдэнэ.

9.1.9. Хүүхэд, гэр бүлийн цахим зохистой хэрэглээг нэмэгдүүлнэ.

9.2. Хөтөлбөрийн зорилтыг тоон үзүүлэлтээр төсөөлөн томъёолбол

9.2.1. Төрийн үйлчилгээний хурд 30-45 хувиар хурдасна.

9.2.2. Иргэдэд мэдээлэл хүргэх зардал 40-50 хувиар багасна.

9.2.3. Нийтийн эзэмшлийн газар, зам талбайд үйлдэгдэх гэмт хэргийн гаралт 10 хүртэл хувиар буурах, илрүүлэлт мөн хувиар өснө.

9.2.4. Аймгийн хэмжээний төрийн байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг салбар бүрд 10-20 хувь нэмэгдүүлнэ.

9.2.5. Нээлттэй мэдээллийг иргэн бүрт хүргэх суваг бий болгоно. Иргэд төрийн 50 хүртлэх үйлчилгээг цахимаар авдаг болно.

9.2.6. Нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг ил тод, хүртээмжтэй болгосноор, хэрэгжилт 30-с доошгүй хувиар нэмэгдэнэ.

Арав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

10.1.Хөтөлбөрийн бүх ажлыг аймгийн хэмжээнд нэгтгэн удирдах хороог байгуулна.

10.1.1.Удирдах хорооны дарга аймгийн Засаг дарга байна.

10.1.2.Хөтөлбөрийн өдөр тутмын хэрэгжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар томилсон ажлын хэсэг хэрэгжүүлж, хяналт арга зүйгээр хангана.

10.1.3.Хөтөлбөр, төсөл бүрийн хэрэгжилт, ажлын явцыг тухайлсан нэгжүүд хариуцан ажиллана.

10.1.4.Хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх байгууллагууд нь:

- ❖ Аймгийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагууд
- ❖ Бусад төрийн байгууллагууд
- ❖ Олон улсын байгууллага
- ❖ Төрийн бус байгууллага
- ❖ Иргэний нийгмийн байгууллагууд
- ❖ Хувийн хэвшлийн байгууллагууд
- ❖ Иргэд, олон нийт байна.

10.2.Хөтөлбөрийг олон төслүүд болгон хувааж хэрэгжүүлнэ.

10.2.1.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийг удирдах түр ажиллагаатай нэгж байгуулна.

10.2.2.Төслийн хэрэгжүүлэх нэгжүүдэд туслах зорилгоор бусад баг байгуулж болно.

10.3.Хөтөлбөрийн дагуу гүйцэтгэх зарим ажил үйлчилгээнүүдийг төрийн холбогдох бусад байгууллагуудтай зөвшилцөж, хамтран хэрэгжүүлнэ.

10.4.Төслүүдийн хэрэгжилтийг иргэдийн оролцоотойгоор тогтмол хянаана.

10.5.Төслүүдийн гүйцэтгэлд өндөр мэргэжлийн экспертүүдээр хөндлөнгийн дүгнэлт гаргуулж болно.

10.6.Төслүүдийг аль болох үндэсний болон орон нутгийн мэргэжилтэн, байгууллагуудаар гүйцэтгүүлэхийг эрмэлзэх ба дотоодын хүчээр хийж гүйцэтгэх боломжгүй төсөл, технологид гадаад шийдэл, гүйцэтгэгчийг оролцуулна.